



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/370

Хэрлэн сум

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/157 дугаартай захирамжаар "Ган баялагийн орд ХХК"-д эзэмшүүлсэн газрыг тус сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/99 дугаартай захирамжаар зориулалтын дагуу 2 жил ашиглаагүй гэх үндэслэлээр хүчингүй болгосон нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг хангаагүй болох нь тогтоогдсон байх тул Бор-Өндөр сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/99 дугаартай захирамжийг хүчингүй болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатарт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ